



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 1/64

Баян-Өндөр сум

Г Тохиолдол удирдлагын тогтолцооны Т  
бүрэлдэхүүнийг томилох тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4, 12.1.5, 13 дугаар зүйлийн 13.7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2, 34.2.3, Монгол улсын Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан "Болзошгүй гамшиг осол, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн тохиолдлын удирдлагын тогтолцоо, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам"-ын 3.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/328, 2018 оны А/527, 2022 оны А/373, 2024 оны А342 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Болзошгүй гамшиг осол, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн тохиолдол удирдлагын тогтолцооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, тохиолдол удирдлагын тогтолцооны бүрэлдэхүүн, оролцох эрүүл мэндийн байгууллагуудын чиг үүргийг хоёрдугаар, болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлыг мэдээлэх мэдээллийн урсгал, хариу арга хэмжээний зураглалыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Болзошгүй гамшиг осол, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн тохиолдлын удирдлагын тогтолцоог идэвхжүүлэн хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, бэлэн байдлыг хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний ахлах мэргэжилтэн /П.Хишгээ/, эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Тохиолдлын удирдлагын тогтолцоо, хариу арга хэмжээний зардалд шаардагдах төсвийн тооцоолол, санхүүжилтийг гаргахыг Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн /Д.Отгондэлгэр/, Санхүү нягтлан бодох бүртгэлийн

ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/, эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Уртнасан/-д даалгасугай.
5. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2022 оны Эрүүл мэндийн газрын даргын А/09 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ

Эрүүл мэндийн газрын даргын  
2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн  
1/64 дугаар тусгаар хавсралт



## ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Тохиолдлын удирдлагын багийн дарга: Эмнэлгийн тусламжийн чанар эрсдэл, магадлан итгэмжлэл хариуцсан ахлах мэргэжилтэн П. Хишгээ

Тохиолдлын удирдлагын багийн дэд дарга: Нийгмийн эрүүл мэндийн төвийн ахлах мэргэжилтэн А. Ганчимэг

№	Нэр	Албан үүрэг	Албан тушаал
<b>1. ТӨЛӨВЛӨЛТ, ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ БАГ</b>			
1.	Г. Энхжаргал	Багийн дарга	Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн
2.	Б. Уртнасан	Багийн гишүүн	Бодлого төлөвлөлт, хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн
3.	Г. Итгэл	Багийн гишүүн	Эрүүл мэндийн статистик мэдээллийн мэргэжилтэн
<b>2. ХАВЬТАЛ ИЛРҮҮЛЭЛТИЙН БАГ</b>			
1.	Б. Солонго	Багийн дарга	Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч
2.	Ч. Мөнхзул	Багийн гишүүн	Эмнэлгийн дотоод халдвар хариуцсан мэргэжилтэн
3.	А. Хонгорзул	Багийн гишүүн	Халдварт бус өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан мэргэжил
4.	С. Эрдэнэцэцэг	Багийн гишүүн	Эрүүл мэндийн статистик, бүртгэл мэдээний сан хариуцсан ажилтан
5.	Т. Энхтуяа	Багийн гишүүн	Мэндцэцэн өрхийн эрүүл мэндийн төвийн дарга
<b>3. ТАНДАЛТЫН БАГ</b>			
1.	Б. Будсүрэн	Багийн дарга	Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч
2.	Б. Хулан	Багийн гишүүн	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тархвар судлагч
3.	Г. Ангар	Багийн гишүүн	Эмнэлэг сувиллын цогцолборын тархвар судлаач
4.	М. Уранчимэг	Багийн гишүүн	Эрдэнэт Медикал төрөлжсөн эмнэлгийн тархвар судлаач
5.	Э. Энхчимэг	Багийн гишүүн	Анхны оч өрхийн эрүүл мэндийн төвийн эмч
<b>4. ДАРХЛААЖУУЛАЛТЫН БАГ</b>			
1.	П. Отгонбилэг	Багийн дарга	Дархлаажуулалт, зоонозын халдварт өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн
2.	Б. Энхтүвшин	Багийн гишүүн	Дарлаажуулалтын бага эмч
3.	Б. Батцэцэг	Багийн гишүүн	Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ хариуцсан ажилтан
4.	Н. Мөнгөнцацралт	Багийн гишүүн	Орчны эрүүл мэнд, нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
4.	Г. Энхзаяа	Багийн гишүүн	Сувилахуй болон хөнгөвчлөх, тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
<b>5. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ШУУРХАЙ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ БАГ</b>			
1.	М. Алтанбек	Багийн дарга	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн -

			Эмнэлзүй эрхэлсэн орлогч захирал
2.	Д.Оюунтунгалаг	Багийн гишүүн	Эмчилгээ чанарын хяналтын улсын байцаагч
3	Л.Цэрэнлхам	Багийн гишүүн	Хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
4	А.Хонгорзул	Багийн гишүүн	Анхан шатны эрүүл мэндийн байгууллага, ахмад настны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
5	Мөнхжаргал	Багийн гишүүн	Эрдэнэт Медикал Эмчилгээ эрхэлсэн орлогч
6	Л.Машбат	Багийн гишүүн	Эрдэнэт клиник Эмчилгээ чанарын албаны дарга
7	Б. Жаргалсайхан	Багийн гишүүн	Өрхийн анагаах ухааны холбооны тэргүүн
8	Ц. Дэлгэрмаа	Багийн гишүүн	Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн дарга
9	Т.Болорзул	Багийн гишүүн	Хувийн хэвшлийн Чандмань эрдэнэ холбооны тэргүүн
<b>6.ЭРСДЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ,ХАРИЛЦАА ХОЛБООНЫ БАГ</b>			
1	А. Ганчимэг	Багийн дарга	Нийгмийн эрүүл мэндийн төвийн ахлах мэргэжилтэн
2	Б.Лхагвадэмбэрэл	Багийн гишүүн	Олон нийттэй харилцах ажилтан
3	Х.Оюун-Эрдэнэ	Багийн гишүүн	Мэдээлэл технологи, цахим эрүүл мэнд, байгууллагуудын үйл ажиллагааны автоматжуулалт, сүлжээ хариуцсан мэргэжилтэн
4	Б.Батсүх	Багийн гишүүн	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн - Сургалт, эрдэм шинжилгээ инновацийн албаны дарга
5	Э. Чимэдцогзол	Багийн гишүүн	Үйлсбадрах өрхийн эрүүл мэндийн төвийн дарга
<b>7. ЛАБОРАТОРИЙН БАГ</b>			
1	Д.Жаргал	Багийн дарга	Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч
2	Л.Баяржаргал	Багийн гишүүн	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн лабораторын тасгийн эрхлэгч
3	Л.Байгаль	Багийн гишүүн	Баян-Өндөр мед төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн захирал
4	Б.Цандмаа	Багийн гишүүн	Эрдэнэт Медикал төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн лабораторийн эрхлэгч
5	Э. Эрдэнэжаргал	Багийн гишүүн	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн вирусологи лабораторын эмч
6	Э. Анхтуяа	Багийн гишүүн	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн бактериологи лабораторын эмч
<b>8.САНХҮҮ, НӨӨЦИЙН БАГ</b>			
1	Д.Отгондэлгэр	Багийн дарга	Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
2	Г.Нарандарь	Багийн гишүүн	Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн
3	Б.Баттогтох	Багийн гишүүн	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Үйл ажиллагаа эрхэлсэн захирал
4	О.Анхбаяр	Багийн гишүүн	Эмийн бодлогын хэрэгжилт, чанар аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан

			мэргэжилтэн
5	Н. Амаржаргал	Багийн гишүүн	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмзүйн тасгийн эрхлэгч
6	Л.Бямбаа	Багийн гишүүн	Эм холбооны тэргүүн
<b>9. АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАРИУЦСАН БАГ</b>			
1.	С.Мөнхзул	Багийн дарга	ЭМГ-ын ХАБ-ын ажилтан
2	Б.Пүрэвсүх	Багийн гишүүн	БОЭТ-ийн ХАБ-ын ажилтан
<b>10. СЭТГЭЛ ЗҮЙН БАГ</b>			
1	Б.Батцэцэг	Багийн дарга	ЭМГ-ын сэтгэл зүйч
2	Ж.Должмаа	Багийн гишүүн	БОЭТ-ийн сэтгэцийн эмч
3	М.Бямбасүрэн	Багийн гишүүн	8-р сургуулийн сэтгэл зүйч
<b>11. ЭМНЭЛГИЙН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ УСТГАХ БАГ</b>			
1	Ч.Отгонжаргал	Багийн гишүүн	Ногоон ариусгал ХХК
<b>12. АРИУТГАЛ ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН БАГ</b>			
1	М.Мөнхцэцэг	Багийн гишүүн	Хөх билэгт
2	У.Отгонбаатар	Багийн гишүүн	Ариун ирээдүй
3	М.Эрдэнэчимэг	Багийн гишүүн	Сайн түшиг
4	Д.Алтанцэцэг	Багийн гишүүн	Цасны хачир
5	Н.Уртнасан	Багийн гишүүн	Гүүд удам
6	Л.Долгор	Багийн гишүүн	Үрст бүрд
7	П.Энхбат	Багийн гишүүн	Цифермакс

Эрүүл мэндийн газрын даргын  
2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн  
дугаар тушвалын хавсралт



ТОХИОЛДОЛ УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ

№	ТУТ-ны бүрэлдэхүүний томилгоо	Гүйцэтгэх үүрэг
1	Тохиолдлын удирдлагын багийн дарга	<ul style="list-style-type: none"><li>✓ Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын хариу арга хэмжээнд шаардлагатай мэдээ, мэдээллийг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, бусад улсын болон орон нутгийн албанаас гаргуулан авч, эрүүл мэндийн албаны бүрэлдэхүүн, техник, хэрэгслийн бэлэн байдлыг хангах;</li><li>✓ Тохиолдлын удирдлагын тогтолцооны цар хүч хэрэгслийг томилж ажиллуулах</li><li>✓ Тохиолдлын удирдлагын тогтолцооны бүрэлдэхүүний өргөжүүлэх, багасгах шийдвэрийг гаргах</li><li>✓ Дайчилгаагаар ажиллах хүч, хэрэгслийн судалгаа гаргах, тодотгох, нүүлгэн шилжүүлэх ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх</li><li>✓ Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын чиглэлээр тушаал, албан даалгавар, салбарын хүрээнд баримтлах дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавих, чиглэл, зөвлөмж өгөх</li><li>✓ Голомтод үүрэг гүйцэтгэж буй мэргэжлийн ангийг удирдлагаар хангах, нөхцөл байдлыг үнэлэх, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;</li><li>✓ Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд оролцож байгаа бүрэлдэхүүнд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх;</li><li>✓ Бусад салбар байгууллага, мэргэжлийн ангиудтай харилцан хамтын ажиллагааг зохион байгуулах, Эрүүл мэндийн газрын дарга, Аймгийн онцгой комисс, Шуурхай штабыг холбогдох мэдээллээр хангах</li></ul>
2	Тохиолдлын удирдлагын багийн дэд дарга	<ul style="list-style-type: none"><li>✓ Хариу арга хэмжээний ерөнхий удирдлагыг ханган багуудын үйл ажиллагаа болон хүний нөөцийн төлөвлөлттийг уялдуулан зохицуулах</li><li>✓ Хариу арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой, үүссэн нөхцөл байдалтай холбоотой мэдээ мэдээллээр ЭМГ-ын дарга, бусад салбар байгууллагуудыг хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах</li><li>✓ Хариу арга хэмжээнд шаардлагатай зардлыг төлөвлөх, зарцуулах шийдвэрийг гаргаж, хяналт тавих</li><li>✓ Зарлан дуудагч, аюулгүй байдал хариуцсан ажилтныг өдөр тутмын шууд удирдлагаар ханган ажиллах</li><li>✓ ТУТ-ыг удирдлага арга зүйгээр хангаж, шаардлагатай тохиолдолд голомтын бүсэд ажиллах;</li><li>✓ Цаг үеийн нөхцөл байдлын мэдээ, мэдээлэл, шийдвэрийг эрүүл мэндийн байгууллага, иргэдэд шуурхай хүргэх;</li><li>✓ ТУТ-аас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээг хүлээн авч нэгтгэн хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, мэдээг Аймгийн онцгой комисс, Шуурхай штаб, Онцгой байдлын газарт тухай бүрт гаргаж хүргүүлэх.</li><li>✓ Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрсдэлийн үнэлгээг салбар дундын багаар хийлгэх,</li></ul>

		<p>үнэлгээнд үндэслэн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, мэдээ, тайлан гаргах;</p>
2	Тохиолдлын удирдлагын багийн дэд дарга	<ul style="list-style-type: none"> <li>✓ Хариу арга хэмжээний ерөнхий удирдлагыг ханган багуудын үйл ажиллагаа болон хүний нөөцийн төлөвлөлттийг уялдуулан зохицуулах</li> <li>✓ Хариу арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой, үүссэн нөхцөл байдалтай холбоотой мэдээ мэдээллээр ЭМГ-ын дарга, бусад салбар байгууллагуудыг хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах</li> <li>✓ Хариу арга хэмжээнд шаардлагатай зардлыг төлөвлөх, зарцуулах шийдвэрийг гаргаж, хяналт тавих</li> <li>✓ Зарлан дуудагч, аюулгүй байдал хариуцсан ажилтныг өдөр тутмын шууд удирдлагаар ханган ажиллах</li> <li>✓ ТУТ-ыг удирдлага арга зүйгээр хангаж, шаардлагатай тохиолдолд голомтын бүсэд ажиллах;</li> <li>✓ Цаг үеийн нөхцөл байдлын мэдээ, мэдээлэл, шийдвэрийг эрүүл мэндийн байгууллага, иргэдэд шуурхай хүргэх;</li> <li>✓ ТУТ-аас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээг хүлээн авч нэгтгэн хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, мэдээг Аймгийн онцгой комисс, Шуурхай штаб, Онцгой байдлын газарт тухай бүрт гаргаж хүргүүлэх.</li> <li>✓ Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрсдэлийн үнэлгээг салбар дундын багаар хийлгэх, үнэлгээнд үндэслэн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, мэдээ, тайлан гаргах;</li> </ul>
3	Төлөвлөлт, эрсдэлийн үнэлгээний баг	<ul style="list-style-type: none"> <li>✓ Хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг шуурхай боловсруулан тохиолдлын удирдлагын тогтолцооны бие бүрэлдэхүүний хурлаар хэлэлцүүлэн батлуулах, тогтмол тодотгол хийх</li> <li>✓ Төлөвлөлт хийхэд шаардлагатай бүх төрлийн мэдээллийг мэргэжлийн болон холбогдох байгууллагаас авах, мэдээллийн сан бүрдүүлэх</li> <li>✓ Өдөр тутмын шинэчлэгдсэн мэдээлэлд үндэслэн эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээ хийж танилцуулах, мэдээлэх</li> <li>✓ Үүссэн нөхцөл байдалтай холбоотой бүхий л мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх, хэтийн төлвийг тооцоолох</li> <li>✓ Хариу арга хэмжээний чиглэл, цар хүрээ, шаардагдах нөөцийг /эм, урвалж, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, хүний нөөц, техник хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл/ төлөвлөх</li> <li>✓ Хариу арга хэмжээний явц, үр дүнг тогтмол хянах</li> <li>✓ Хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай заавар, журам, талбан даалгавар зэрэг бодлогын болон техникийн баримт бичгийг боловсруулах, батлуулах</li> <li>✓ Шаардлагатай тохиолдолд нөхцөл байдлыг тандах зорилгоор нэмэлт мэдээлэл цуглуулах</li> </ul>
4	Хавьтал илрүүлэлтийн баг	<ul style="list-style-type: none"> <li>✓ Голомтын хавьтлыг илрүүлэх, мэдээлэх</li> <li>✓ Тусгаарлах арга хэмжээг зохион байгуулах</li> </ul>
5	Тандалтын баг	<ul style="list-style-type: none"> <li>✓ Голомтын тандалт судалгааг хийх</li> <li>✓ Өдөр тутмын өвчлөлийн мэдээ тайланд боловсруулалт хийж, үүссэн нөхцөл байдалтай холбоотой мэдээлэлд дүн шинжилгээ хийх, хэтийн төлвийг тооцоолох, хариу арга хэмжээний явц, үр дүнг тогтмол хянах</li> <li>✓ Хариу арга хэмжээний чиглэл, цар хүрээ, шаардагдах нөөцийг /эм, урвалж, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, хүний нөөц, техник хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл /төлөвлөх</li> <li>✓ Мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах, зөвлөмж боловсруулах</li> </ul>

6	Дархлаажуулалтын баг	<ul style="list-style-type: none"> <li>✓ Дархлаажуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, мэдээ тайланг нэгтгэх, мэдээлэх</li> <li>✓ Дархлаажуулалтад шаардлагатай вакцин,эм эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах,</li> <li>✓ Дархлаажуулалтын чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх</li> </ul>
7	Эрсдлийн харилцаа холбооны баг	<ul style="list-style-type: none"> <li>✓ Бие бүрэлдэхүүнийг зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам, яаралтай цугларах бүдүүвчийг боловсруулж шалгах, тухай бүр тодотгох, дадлага сургууль хийлгэх, гамшгийн голомтод бүх төрлийн холбоог зохион байгуулах,</li> <li>✓ ЭМГ-ын дарга, зохицуулагчийг холбоо, мэдээллээр хангах;</li> <li>✓ Дээд шатны байгууллагад гамшгийн нөхцөл байдлын мэдээг дамжуулах, хүлээн авах, холбооны тасралтгүй ажиллагааг хангах,</li> <li>✓ Үүссэн нөхцөл байдалтай уялдуулан олон нийтэд хийх анхны мэдээллийн төслийг боловсруулах,хэвлэл олон нийтийн цахим сүлжээнд цацагдаж байгаа мэдээ мэдээллийг шүүх, тандалт хийж, хариу арга хэмжээ авах болон шаардлагатай мэдээллийг удирдлагад танилцуулах</li> <li>✓ Хэвлэлийн бага хурлыг зохион байгуулах</li> <li>✓ Өдөр тутмын үйл ажиллагааны шинэчилсэн мэдээллийг бэлтгэх, цахим хуудас,фейсбүүк хуудсаар дамжуулан хүн амыг мэдээллээр тогтмол хангах</li> <li>✓ Зорилтот бүлгийн хүн амыг тогтоох,мэдээллийн хэрэгцээг тогтоох</li> <li>✓ Хүн амд чиглэсэн сэрэмжлүүлэг, санамж зөвлөмж мэдээлэл сургалт сурталчилгааны материалаын эхийг бэлтгэх, түгээх</li> <li>✓ Олон нийтийн хэвлэл,мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийх хуваарь гарган батлуулж,хэрэгжүүлэх</li> </ul>
8	Эмнэлгийн тусламж, шуурхай хариу арга хэмжээний баг	<ul style="list-style-type: none"> <li>✓ Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, үер усны аюулаас үүссэн голомтод эрүүл мэндийн болон нийтийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ, эмнэлэг хүртэлх яаралтай, амиллуулах суурь тусламж үзүүлэх</li> <li>✓ Төлөвлөлтийн багаас боловсруулсан хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжлтийг зохион байгуулах</li> <li>✓ Дайчлагдан ажиллаж буй бие бүрэлдэхүүнийг өртөлтийн өмнөх болон дараахь урьдчилан сэргийлэлтэд хамруулах,эрүүл мэндийг хянах ажлыг зохион байгуулах</li> <li>✓ Төлөвлөлтийн багийг өдөр тутмын мэдээлэлээр хангах, бие бүрэлдэхүүн, багаж тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгсэл, техникийн хүчин чадал, тусламж үйлчилгээний ачаалал эрсдлийг тооцон мэдээ мэдээллээр ТУТ-ын удирдлага, бусад багийг хангаж ажиллах</li> <li>✓ Нэрвэгдэгсдийг шилжүүлэхэд шаардлагатай тусламж үзүүлэх Эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдлыг хангуулах мэдээлэл хүргэх, аюулгүй тээвэрлэж хүргэх</li> <li>✓ Хээрийн эмнэлэг дэлгэх бэлэн байдлыг хангах, эмнэлэг хүртэлхи, эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг үзүүлэх, хүнд өвчтөнийг аюулгүй тээвэрлэх</li> <li>✓ Яаралтай тусламжийн бүлэг, эм, эмнэлгийн хэрэгслээр хангах бүлэг, эрсдэл харилцаа холбооны бүлэг, халдвар эсэргүүцэх хөдөлгөөнт бүлэг, Зооноз өвчинтэй тэмцэх бүлэг, Цус сэлбэх хөдөлгөөнт бүлэг гэсэн бүтцээр газар дээр нь эмнэлгийн тусламж үйлчилгээг нэрвэгсдэд эрэмбэлэн үзүүлэх</li> <li>✓ Хариу арга хэмжээнд ашиглагдах хүний нөөц, эм эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, ороох боох материал, техник, багаж хэрэгсэл, шатах тослох материал, цэвэр ус, хоол</li> </ul>



		<p>хүнс, хувцас, бусад бараа материалын нөөцийн судалгаа гаргах, бүрдүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, нөхөн сэлбэх</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Тусламж үйлчилгээ үзүүлсэн мэдээллийг нэгтгэх, мэдээлэх,</li> <li>✓ Нэрвэгсдэд зөвлөгөө өгөх, мэдээлэл сургалт сурталчилгаа хийх</li> </ul>
9	Лабораторийн баг	<ul style="list-style-type: none"> <li>✓ Лаборатори, бактериологийн шинжилгээг хийх урвалж бодис, оношлуур, хүний нөөцийн бэлэн байдлыг хангах</li> <li>✓ Шаардлагатай шинжилгээг хийх, дүнг мэдээлэх</li> </ul>
10	Санхүү, нөөцийн баг	<ul style="list-style-type: none"> <li>✓ Мэргэжлийн ангийн үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх, хангалтын төлөвлөгөө боловсруулах,</li> <li>✓ Хариу арга хэмжээнд ашиглагдах техник, багаж хэрэгсэл, шатах тослох материал, цэвэр ус, хоол хүнс, хувцас, бусад бараа материалын нөөцийн судалгаа гаргах, бүрдүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, нөхөн сэлбэх;</li> <li>✓ Аврах ажиллагааны багаж хэрэгслийг засварлах, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангуулах, нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах</li> <li>✓ Хариу арга хэмжээнд шаардлагатай эм,эмнэлгийн хэрэгслийн нөөцийг өдөр бүр гаргаж мэдээлж байх</li> <li>✓ Аврах ажиллагааны багаж хэрэгслийг засварлах, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангуулах, нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах;</li> <li>✓ Шаардлагатай бичиг баримтыг хувиран олшруулах, тараах, устгах, баримтжуулах, архивлах</li> </ul>
11	Аюулгүй байдал хариуцсан баг	<ul style="list-style-type: none"> <li>✓ Бие бүрэлдэхүүнд аюулгүй ажиллагааны зааварчилгаа танилцуулж, гарын үсэг зуруулж баталгаажуулах;</li> <li>✓ Дайчилгаагаар ажиллах хүн хүч, техник хэрэгслийн судалгааг гаргах, бэлэн байдлыг шалгах, хөдөлгөөн үйлдэх чиглэлийн талаар зааварчилгаа өгөх;</li> <li>✓ Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл түүний ашиглалт, хадгалалтад хяналт тавих, үзлэг шалгалт, засвар үйлчилгээ хийх;</li> <li>✓ Химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт бодисын судалгааг гаргаж, бүртгэл хөтлөх, тэдгээрийн эргэлтэд хяналт тавих, объектын харуул хамгаалалтад хяналт тавих;</li> <li>✓ Бие бүрэлдэхүүнийг өдөр тутам хоол хүнсээр хангах, аюулгүй тээвэрлэх, ертөлтийн өмнөх болон дараахь урьдчилан сэргийлэлтэд хамруулах, эрүүл мэндийг хянах ажлыг зохион байгуулах</li> </ul>
12	Сэтгэлзүйн баг	<ul style="list-style-type: none"> <li>✓ Нэрвэгсдэд сэтгэлзүйн тусламж үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн байдалд үнэлгээ хийх</li> <li>✓ Шаардлагатай тохиолдолд нэмэлтээр сэтгэлзүйчдийн багийг дуудах, БОЭТ-д хэвтүүлэхээр илгээх</li> <li>✓ Сэтгэлзүйн чиглэлээр зөвлөмж, мэдээлэл хүргэх</li> </ul>
13	Эмнэлгийн аюултай хог хаягдал устгах баг	<ul style="list-style-type: none"> <li>✓ Эмнэлгийн аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах</li> <li>✓ Хог хаягдлын мэдээ мэдээллийг нэгтгэж өгөх</li> </ul>
14	Ариутгал халдваргүйтгэлийн баг	<ul style="list-style-type: none"> <li>✓ Халдваргүйтгэл хийх багаж хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, хүний нөөц, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлэх</li> <li>✓ Голомтод халдваргүйтгэлийг журмын дагуу хийж гүйцэтгэх, зарцуулсан бодисын болон нөөцийн мэдээллийг тухай бүрт гаргаж өгөх, эргэн мэдээлэлээр хангах</li> </ul>

**ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНД ОРОЛЦОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН  
БАЙГУУЛЛАГУУДЫН ЧИГ ҮҮРЭГ**

№	Байгууллагын нэр	Гүйцэтгэх үүрэг
1	Эрүүл мэндийн газар	<ul style="list-style-type: none"> <li>✓ Тохиолдлын удирдлагын тогтолцоог идэвхжүүлэх, тохиолдлын удирдлагын тогтолцооны бүрэлдэхүүнийг өргөжүүлэх, багасгах шийдвэрийг гаргах</li> <li>✓ Дайчилгаагаар ажиллах хүч, хэрэгслийн судалгаа гаргах, тодотгох, нүүлгэн шилжүүлэх ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх</li> <li>✓ Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын чиглэлээр тушаал, албан даалгавар, салбарын хүрээнд баримтлах дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавих, чиглэл, зөвлөмж өгөх</li> <li>✓ Голомтод үүрэг гүйцэтгэж буй мэргэжлийн байгууллагуудыг удирдлагаар хангах, нөхцөл байдлыг үнэлэх, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;</li> <li>✓ Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд оролцож байгаа бүрэлдэхүүнд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх;</li> <li>✓ Бусад салбар байгууллага, мэргэжлийн ангиудтай харилцан хамтын ажиллагааг зохион байгуулах, Эрүүл мэндийн газрын дарга, Аймгийн онцгой комисс, Шуурхай штабыг холбогдох мэдээллээр хангах</li> </ul>
2	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	<ul style="list-style-type: none"> <li>✓ Тандалт судалгаа хийж, голомтыг цомхотгох үйл ажиллагааг явуулах</li> <li>✓ Нэмэлтээр ор дэлгэж, эмнэлгийн тусламж үйлчилгээг эрэмбэлэн үзүүлэх</li> <li>✓ Эмнэлгийн тусламж үзүүлэх хүний нөөц, багаж тоног төхөөрөмж, ор, эм эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материал, техник хэрэгсэл, шатахууны бэлэн байдлыг хангах,</li> <li>✓ Тусламж үйлчилгээ үзүүлсэн мэдээллийг нэгтгэх, мэдээлэх,</li> <li>✓ Нэрвэгсдэд зөвлөгөө өгөх, мэдээлэл сургалт сурталчилгаа хийх</li> <li>✓ Лабораторийн болон нян судлалын шинжилгээг заалтаар хийх</li> <li>✓ Явуулаар тусламж үйлчилгээ үзүүлэх баг томилох, тээвэрлэх, тусгаарлах</li> <li>✓ Мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх</li> </ul>
3	Сум, өрхийн эрүүл мэндийн төв	<ul style="list-style-type: none"> <li>✓ Тандалт судалгаа хийж, голомтыг цомхотгох үйл ажиллагааг явуулах</li> <li>✓ Голомтод эмнэлгийн тусламж үйлчилгээг явуулаар хүргэх, шаардлагатай иргэдийг эрэмбэлэх, хээрийн эмнэлэгт илгээх, ялган оношилгоо хийх, хяналтад авах</li> <li>✓ Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх</li> <li>✓ Эмнэлгийн тусламж үзүүлэх хүний нөөц, багаж тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материал, техник хэрэгсэл, шатахууны бэлэн байдлыг хангах</li> <li>✓ Тусламж үйлчилгээ үзүүлсэн мэдээллийг нэгтгэх, мэдээлэх,</li> <li>✓ Нэрвэгсдэд зөвлөгөө өгөх, мэдээлэл сургалт сурталчилгаа хийх</li> <li>✓ Дархлаажуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, мэдээ мэдээллийг нэгтгэх</li> </ul>
4	Эрдэнэт медиал, Эрдэнэт клиник, сувилал болон Хувийн хэвшлийн	<ul style="list-style-type: none"> <li>✓ Нэмэлтээр ор дэлгэж эмнэлгийн тусламж үйлчилгээг тусгай зөвшөөрлийн дагуу эрэмбэлэн үзүүлэх</li> <li>✓ Эмнэлгийн тусламж үзүүлэх хүний нөөц, багаж тоног төхөөрөмж, ор, эм эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материал,</li> </ul>

	ортой клиник	<p>техник хэрэгсэл, шатахууны бэлэн байдлыг хангах ,</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Тусламж үйлчилгээ үзүүлсэн мэдээллийг нэгтгэх, мэдээлэх,</li> <li>✓ Нэрвэгсдэд зөвлөгөө өгөх, мэдээлэл сургалт сурталчилгаа хийх</li> <li>✓ Дархлаажуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, мэдээ мэдээллийг нэгтгэх</li> </ul>
5	ЭХНБайгууллагууд	<ul style="list-style-type: none"> <li>✓ Аймгийн хэмжээнд байгаа эм,эмнэлгийн хэрэгслийн нөөц болон шаардлагатай эм ,эмнэлгийн хэрэгслийн нөөцийн мэдээллийг гаргах ,татан авах</li> <li>✓ Голомтод шаардлагатай эм,эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материалаар хангах, хандивлагч олох</li> </ul>
6	Шүдний клиникүүд	<ul style="list-style-type: none"> <li>✓ Голомтод эмнэлгийн тусламж үйлчилгээг явуулаар хүргэх</li> <li>✓ Хавьтлыг илрүүлэх, тусгаарлахад оролцох</li> </ul>

Эрүүл мэндийн газрын даргын  
2024 оны 08 дугаар сарын 08 -ны өдрийн  
дугаар тушаалын хэвсрэлт



**БОЛЗОШГУЙ ГАМШИГ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НОЦТОЙ БАЙДАЛД ХҮРГЭЖ  
БОЛЗОШГУЙ ҮЙЛ ЯВДЛЫГ МЭДЭЭЛЭХ ЗУРАГЛАЛ**

